



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Барилга, хот байгуулалтын яам

Бодлого, төлөвлөлтийн газрын Орон сууц, санхүүжилтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн дарга

Эрхэлсэн түшмэл, ТЗ-11

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах хүрээнд өрхийн худалдан авах чадвар, эрэлт, хэрэгцээнд нийцсэн өртөг бүхий орон сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах, удирдлага, арга зүйгээр дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд нэгжийг удирдан гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан орон сууцны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх;

2.Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн тогтолцоог боловсруулах, оролцогч байгууллагуудын уялдааг хангуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.Түрээсийн орон сууцны тогтолцоог сайжруулах, түрээсийн орон сууцны санг төр, хувийн хэвшлийн оролцоотой нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны асуудал эрхэлсэн байгууллагыг удирдлага, арга зүйгээр хангах;

4.Төрөөс иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар хангах төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах;

5.Удирдлагаас хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах – Т, Хариуцан гүйцэтгэх – Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Орон сууцны тухай хууль, дүрэм, журам болон бусад холбогдох бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах, санал өгөх, удирдлага, зохицуулалтаар хангах;	Эрх зүйн орчин сайжирсан байна.	Г, Х, Ш
	2.Хүн амыг орон сууцаар хангахад шаардлагатай тооцоо, судалгаа, стратеги төлөвлөгөө боловсруулах, удирдлага, арга зүйгээр хангах;	Тооцоо, судалгаа хийгдэж, төлөвлөгөө боловсруулагдсан байна.	Г, Х, Ш
	3.Орон сууцтай холбогдсон мэдээ, судалгааг нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, удирдлага, иргэд, олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах;	Бодитой, судлагдсан мэдээллээр хангасан байна.	Г, Х, Ш
	4.Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, удирдлага, арга зүйгээр хангах.	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1.Гадаадын улс, оронд хэрэгжүүлсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог судалж, хувилбарт санал боловсруулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;	Туршлага нэвтрүүлсэн байна.	Г, Х, Ш
	2.Монгол Улсын онцлогт тохирсон, хөрөнгийн нөөцөнд үндэслэсэн ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн хөтөлбөр, журам, дүрэм боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, удирдлага, арга зүйгээр хангах;	Ипотекийн зээлийн хөтөлбөр боловсруулагдаж, хэрэгжсэн байна.	Г, Х, Ш



	3.Ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар тооцоо, судалгаа хийж, мэдээллээр хангах;	Жил бүл ипотекийн зээлийн санхүүжилтийг холбогдох эх үүсвэрээс шийдвэрлүүлсэн байна.	Г, Х, Ш
	4.Ипотекийн зээлийн тогтолцоонд оролцогч байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох.	Хамтын ажиллагааг сайжирсан байна.	Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1.Орон сууцны зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн судалгаа, тооцоог боловсруулах, тэдэнд тохирсон хөтөлбөр, журам, дүрэм боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах;	Зорилтот бүлгийн иргэдэд зориулсан орон сууцны хөтөлбөр боловсруулсан байна.	Г, Х, Ш
	2.Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх талаар санал бэлтгэж, шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Түрээсийн орон сууцны сан нэмэгдсэн байна.	Г, Х, Ш
	3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх.	Түрээсийн орон сууцны сан нэмэгдсэн байна.	Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудыг төрөөс дэмжиж, хамтран ажиллах;	Хамтарч төсөл хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	2.Гадаадын түнш, донор орон, олон улсын байгууллагуудтай иргэдийг орон сууцжуулах хүрээнд хамтран ажиллах;	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн байна.	Г, Х, Ш
	3.Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, шинэ суурьшлын бүс, хаяа, дагуул хот, хөдөө орон нутагт хямд өртөгтэй орон сууц барих хувийн хэвшлийг төрөөс үзүүлэх боломжит бодлогоор дэмжиж ажиллах;	Хувийн хэвшилтэй хамтарч төсөл хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	4.Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл солилцох;	Хамтын ажиллагааг сайжруулсан байна.	Г, Х, Ш
	5.Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газар, орон сууцны төслүүдийн сан үүсгэж, гадаад, дотоодын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлыг дэмжих, удирдлага арга зүйгээр хангах.	Төсөл хөтөлбөрийн сан бүрдэж, холбох байгууллагад хандсан байна.	Г, Х, Ш
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;	Ёс зүйн болон бусад төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлсэн байна.	Г



	2.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;	Цаг хугацаандаа шударгаар биелүүлж, гүйцэтгэсэн байна.	Г
	3.Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.	Мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдал бүрэн хангагдсан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол		- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил		- Иргэний ба үйлдвэрийн барилга, байгууламж /0732/; - эдийн засаг /0311/ - төрийн удирдлага /041303/; - яамны үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны чиглэлийн мэргэжлийн инженер.
Мэргэшил		- Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх; - удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх.
Туршлага		- Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн тайлагнах, дүгнэх; - гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, зөрүүг арилгах чиглэлээр зөвлөгөө, чиглэл өгөх чадвартай байх; - байгууллагын эрсдэлийн удирдлага, эрхэмлэх зүйлсийг хэрэгжүүлэх; - албан хаагчдын хувийн зан төлөв зэрэг хувь хүнтэй холбоотой асуудлыг мэдэрч удирдах; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүй эзэмшсэн байх; - мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх; - судалгааны үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- хуульд нийцсэн шийдвэр гаргах; - тэгш, шударга, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээг баримталж шийдвэр гаргах; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - бусад.
	Манлайлах	- ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - тууштай, зарчимч, ажил хэрэгч, шударга зарчмыг баримтлах зэргээр үлгэрлэх;



		- цагийн менежмент сайтай байх; - бусад.
	Бусад	- шаардлагатай хэрэглээний программ хангамжийг ашиглах чадвартай байх; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - багаар ажиллах чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- тасгийн дарга
- ахлах шинжээч
- шинжээч
- ахлах мэргэжилтэн
- мэргэжилтэн
- ахлах зохион байгуулагч

Нийт: 2

Бусад харилцах субъект:

- УИХ, ЗГХЭГ, ЕТГ болон УИХ, ЗГ-ын харьяа төрийн захиргааны байгууллагууд;
- Яам, агентлаг, нугийн захиргааны болон бусад төрийн байгууллагууд;
- Төрийн бус байгууллагууд;
- Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд;
- Иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Б. Ариун
(Гарын үсэг)

Д. БАЯРСАЙХАН
(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 10 дугаар сарын 14-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 20 10 14

Дугаар: 340

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Шийдвэрийн огноо:

Дугаар:
(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

(Гарын үсэг)

С. МАГНАЙСҮРЭН
(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр

